



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ

ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2022

ТӨЛӨВЛӨГӨӨТ

Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн төлөвлөгөөт хяналт шалгалтын нэгдсэн тайлан.

УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ДҮН МЭДЭЭ

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/318 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилт, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам, Харилцан холболтын журам, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам зэрэг холбогдох хууль тогтоомжийн биелэлт, үйлчилгээндээ мөрдөх стандарт, техникийн нөхцөлийг хангасан байдлыг газар дээр нь очиж хяналт, шалгалт хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.

1. Тусгай зөвшөөрөл, баримт бичиг, нөхцөл шаардлагын биелэлтийн хүрээнд:

- Зохицуулалтын үйлчилгээний хөлс болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн үлдэгдэлтэй 3 үйлчилгээ эрхлэгч, гэрээ шинэчлэн байгуулаагүй 4 үйлчилгээ эрхлэгч байна.
- Өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмын дагуу үйлчилгээ эрхлэгчид өөрийн гэсэн цахим хуудастай болж, журамд заасан мэдээллүүдийг ил тод байрлуулах шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгааг авч үзэхэд: 10 үйлчилгээ эрхлэгч өөрийн гэсэн цахим хуудастай болов ч журамд заасан мэдээллүүдийг дийлэнх нь ил тод байршуулаагүй.
- Гамшгийн үеийн нэгдсэн удирдлага, гамшгаас хамгаалах төлөвлөгөө гаргасан байдлыг авч үзэхэд 9 үйлчилгээ эрхлэгч гамшгийн үеийн төлөвлөгөөг гаргаж үйл ажиллагаандаа мөрддөг. Харин гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системийг үйлчилгээнд нэвтрүүлж, ашиглаж байгаа 8 үйлчилгээ эрхлэгч байна.
- Үйлчилгээний найдвартай ажиллагааны журамтай эсэхийг авч үзэхэд дийлэнх хувь нь тус журмыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Зарим газрууд тус журмыг боловсруулаагүй ба үйлчилгээний найдвартай ажиллагааг хэрхэн хангаж ажилладаг нь тодорхойгүй байна.
- Үйлчилгээнд ашиглаж байгаа хэрэглэгчийн төхөөрөмж нь итгэмжлэгдсэн байгууллагын тохирлын гэрчилгээтэй байх шаардлагын тухайд тохирлын гэрчилгээгүй 3, Зохицуулах хорооноос олгосон гэрчилгээний хугацаа нь дуусаж, сунгуулах хүсэлт өгсөн 2, хэрэглэгчийн төхөөрөмж ашигладаггүй 1, үйлдвэрлэгчээс олгосон итгэмжлэгдсэн байгууллагын гэрчилгээтэй 3, Зохицуулах хорооноос олгосон тохирлын гэрчилгээтэй 3 үйлчилгээ эрхлэгч байна.

Юнивизи ХХК	
Скаймедиа корпораци ХХК	
Шинэ сансар кабель ХХК	
Монголын цахилгаан холбоо ХК	
Сансар Дижитал ХХК	
Эв Би Си ХХК	
Талст эрчим ХХК	
Оптимум нэтворк ХХК	
ДДэш ТВ ХХК	
Монголсат нэтворкс ХХК	
Мобинет ХХК	
Ормедиа ХХК	
Хийморь кабелийн телевиз ХХК	



Зохицуулалтын үйлчилгээний төлбөрийн үлдэгдэлтэй – 3
Гэрээ шинэчлэн байгуулаагүй – 4
Үйл ажиллагаа явуулаагүй – 1

2. Үйлчилгээнд болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр тавигдах шаардлага хангасан байдал:

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь дуудлагын төв болон цахим хуудсаар үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэдэг бол зарим үйлчилгээ эрхлэгчид нь хэрэглэгчийн бүртгэлтэй майл хаяг болон утасны дугаарт үйлчилгээний талаарх мэдээллийг дамжуулдаг. Хэрэглэгчийн дуудлага, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журамтай байх гэсний дагуу 9 үйлчилгээ эрхлэгч тус журмыг өөрийн үйлчилгээний онцлогт тохируулан, боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа эсэх үзүүлэлтээр: 3 үйлчилгээ эрхлэгч нь журам байхгүй, үйлчилгээний гэрээнд энэ талаарх мэдээлэл тусгаагүй нь мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа нь тодорхойгүй байсан бол 1 үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийн хувийн мэдээллээр бүртгэл хийддэггүй. Харин Улаанбаатар хотын нийт ОСДҮЭ-н 8 үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тогтолцоог бүрдүүлж, дотоод журамтай байх шаардлага хангасан байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн гэрээг нэг бүрчлэн хянаж үзэхэд хэлбэрийн хувьд ихэнх нь үсгийн хэмжээ жижиг, бүдэг, хэрэглэгч уншиж ойлгоход төвөгтэй байдлаар бичигдсэн ба агуулгын хувьд гэрээнд төлбөрийн мэдээлэл, багцын мэдээлэл, багцад багтсан сувгийн жагсаалт, эцэг эхийн хяналт ашиглах заавар, нэмэлт үйлчилгээтэй холбоотой заавар мэдээлэл, хэрэглэгч өөрийн хэрэглээг хянах заавар зэргийг тусгаагүй, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах тухай заалт нь хэрэглэгчийн эрх ашгийг хөндөж болзошгүй, энэ тухай мэдэгдлийг хүргэх арга хэлбэр нь төвөгтэй, хэрэглэгчид чирэгдэл учруулахуйц, мөн хэрэглэгч үйлчилгээг хугацаанаасаа өмнө цуцлах тохиолдолд үйлчилгээний төлбөр болон төхөөрөмжийн төлбөрийг бүтэн нэхэмжилдэг, төхөөрөмжийг буцаах боломжгүй, үйлчилгээ саатах тохиолдолд нөхөн төлбөр олгох болон авах арга хэмжээний талаар заалт гэрээнд тусгаагүй зэрэг нийтлэг зөрчлүүдтэй.

Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журамд хэрэглэгч төлбөр төлөөгүй тохиолдолд олон нийтийн телевизийн үндсэн сувгийг гэрээнд заасан тодорхой хугацаанд үзэх боломжтой байна гэж заасан байдаг ч МҮОНТ-ийн үндсэн сувгийг ямар хугацаанд үзэх талаар хэрэглэгчийн гэрээнд тодорхой заалт байхгүй байгаа дутагдал нийтлэг байв.

Гэрээнд үйлчилгээ үзүүлэгч талын эрх ашгийг хамгаалсан, хариуцлагаас чөлөөлсөн шинжтэй заалтууд нийтлэг орсон байгаа нь хэт нэг талыг барьсан, хэрэглэгчийн эрх ашгийг хөндөж болзошгүй байдалтай гэж үзэхээр байна.

Үйлчилгээний багц дахь сувгуудын байршил, суваг нэмэх, хасах өөрчлөлтийг дангаараа хийх эрхтэй, үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт орох бол гэрээнд заасан сувгаар мэдэгдэх ба ингэснээр гэрээнд өөрчлөлт орсонд тооцно гэсэн заалт үйлчилдэг тул мэдээлэл хүргэх сувгийг хүртээмжтэй хэлбэрээр тухайлбал нүүр хуудас, промо суваг зэрэг өөрийн үйлчилгээний сувгаар хүргэх заалтыг мөн тодорхой тусгах нь зүйтэй.

Зарим үйлчилгээ эрхлэгчдийн хувьд төхөөрөмж борлуулахтай холбоотой харилцааг голчлон зохицуулсан буюу олон суваг дамжуулах үйлчилгээний гэрээ гэхээс илүү хэрэглэгчийн төхөөрөмж борлуулах гэрээний нөхцөлүүдтэй байгаа нь шаардлага хангахгүй байна.

Иймд хяналт, шалгалтын дүнг үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлэхдээ үйлчилгээ эрхлэгч тус бүрээр хэрэглэгчийн гэрээтэй холбоотой цаашид засаж сайжруулах, анхаарах талаар зөвлөмжийг хүргүүлж ажиллана.

3. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад тавигдах шаардлага хангасан байдал:



Нийт ОСДҮЭ-ийн 70% нь хүүхдийн сэтгэхүй, оюун санаа, хөгжил төлөвшилд сөргөөр нөлөөлж болохуйц зохисгүй агуулгатай контент болон телевизийн сувгийг түгжих буюу эцэг, эхийн функцийг өөрийн үйлчилгээнд нэвтрүүлж, хэрэглэгчийн төхөөрөмжөөс эцэг, эх хүссэн сувгаа сонгон түгжих боломжийг бүрдүүлсэн. Мөн зааврыг гарын авлага, цахим хуудсан дээр мэдээлсэн байна. Харин заавар, гарын авлага гаргаагүй 5 үйлчилгээ эрхлэгч байна.

Цаашид үйлчилгээ эрхлэгчид хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад тавигдах шаардлагыг чанд мөрдөж, хэрэглэгчдэдээ тодорхой, ойлгомжтой байдлаар хүргэх, заавар зөвлөгөө өгч байгаа хэлбэр, хүртээмжийг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.


4. Радио, ТВ-ийг дамжуулахад тавигдах шаардлага хангасан байдал:

Дотоодын сувгуудыг дамжуулж байгаа хэдий ч шинэчилж байгуулсан техник холболтын гэрээний явц хангалтгүй, гэрээний хугацаа нь дууссан байдалтай байна.

Харилцан холболтын журмын 2.3 дах заалтыг хэрэгжүүлэх үүднээс 2021-2022 онд олон суваг дамжуулах үйлчилгээний гэрээний ерөнхий нөхцөл /RIO/-г шинэчлэн боловсруулж, Хороогоор хянуулан, баталгаажуулж олон нийтэд нээлттэй ил тод байршуулсан. Үүнтэй холбоотойгоор техник холболтын гэрээг шинэчлэн байгуулж, Хороонд бүртгүүлэх үүргийн биелэлтийг доорх хүснэгтээр харуулав.

№	Үйлчилгээний нэр	Дамжуулж буй дотоод сувгийн тоо	Шинэчилж гэрээ байгуулсан сувгийн тоо	Хувь %/	Тайлбар
1	Талст эрчим ХХК	43	0	0%	ОТТ нэвтрөж ХХК-тай гэрээ байгуулж, сувгийн сигналуудыг авдаг. Тус компанитай байгуулсан гэрээ ирүүлээгүй.
2	Оптимум нэвтрөж ХХК	41	0	0%	Медиа профессионал ХХК-тай гэрээ байгуулж, сувгийн сигналуудыг авдаг. Тус компанитай байгуулсан гэрээ ирүүлээгүй.
3	Монголын цахилгаан холбоо ХК	53	53	100%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан. Өөрийн байранд зааглах цэг хийдэг. МҮОНТВ дээр байрлах 4 ТВ-ийн сувгийг Медиа профессионал ХХК-тай гэрээ байгуулж, сувгийн сигналуудыг авдаг.
4	Монголсат нэвтрөж ХХК	53	43	81,1%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан ЭсТиБиЭс ХХК болон Медиа профессионал ХХК-тай гэрээ байгуулж, ТВ сигналуудаа авдаг. Гэрээ ирүүлсэн.
5	Сансар Дижитал ХХК	42	20	47,6%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан :ЭсТиБиЭс ХХК-тай гэрээ байгуулж, ТВ сигналуудаа авдаг. Гэрээ ирүүлсэн.
6	Шинэ сансар кабель ХХК	58	28	48,3%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан .Сансар дижитал ХХК-тай гэрээ байгуулж, ТВ сигналуудаа авдаг. Гэрээ ирүүлсэн.

7	Мобинет ХХК	29	29	100%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан. ОТТ нэвтрөх ХХК-тай гэрээ байгуулж 12 ТВ суваг, 2 ТВ-ийн байр, Медиа про, ЭнБиСи ХХК-иудын байранд байрлах тоног төхөөрөмжөөр дамжуулж бусад сувгуудыг хүлээн авдаг.
8	Ори медиа ХХК	20	0	0%	Мобинет ХХК-тай бартерын гэрээ байгуулж, ТВ сигналуудаа авдаг. Гэрээ ирүүлээгүй.
9	Юнивишн ХХК	61	38	62,3%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан ТВ-ийн байрнаас очиж сигналуудыг авдаг. Орон нутгийн 54 сувгийг дамжуулдаг.
10	ДДэш ТВ ХХК	57	30	53,6%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан ХУД дэх Дата центрээс сигналуудыг авдаг. Орон нутгийн 22 ТВ сувгийг дамжуулдаг.
11	Эн Би Си ХХК	67	48	71,6%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан Дийлэнх ТВ сигналыг өөрийн байран дах зааглах цэгээр авдаг. Бусдыг нь дундын Медиапро болон Сансар КаТВ-ээс гэрээний дагуу авдаг.
12	Скаймедиа корпораци ХХК	59	32	54,2%	Телевизүүдтэй техник холболтын гэрээ байгуулсан ТВ-ийн байрнаас очиж сигналуудыг авдаг. Орон нутгийн 4 сувгийг дамжуулдаг.
13	Хийморь кабелин телевиз ХХК				



5. Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмын хэрэгжилт:

№	Үйлчилгээний нэр	Үндсэн багцын сувгийн дараалал	Гадаад сувгийн эзлэх хувь	Гадаадын аль нэг улсын сувгийн эзлэх хувь	Гадаадын телевизийн суваг зөвхөн нэг улсынх биш байх
1	Талст эрчим ХХК	Арилжааны тв-н зарим суваг буруу, Монгол сувгууд гадаад сувгийн дунд орсон	56%	27%	Шаардлага хангасан
2	Оптимум нэтворк ХХК	Шаардлага хангана	38.50%	Шаардлага хангана	Шаардлага хангасан
3	Монголын цахилгаан холбоо ХК	Шаардлага хангана	20%	27%	Шаардлага хангасан
4	Монголсат нэтворкс ХХК	Шаардлага хангана	Гадаад суваг байхгүй	Гадаад суваг байхгүй	Гадаад суваг байхгүй
5	Сансар Дижитал ХХК	Арилжааны телевизийн суваг болон өргөн нэвтрүүлгийн телевизийн сувгууд нь холилдсон	26%	31.20%	Шаардлага хангасан
6	Шинэ сансар кабель ХХК	“Таний Монгол” (Арилжааны тв) телевизийн сувгийг олон нийтийн телевизийн бусад сувгийн урд байрлуулсан	42%	28%	Шаардлага хангасан
7	Мобинет ХХК	“Channel11” (Арилжааны тв) телевизийн сувгийг өргөн нэвтрүүлгийн телевизийн дунд байрлуулсан	36%	шаардлага хангана	Шаардлага хангасан
8	Ори медиа ХХК	Шаардлага хангаж байна	Гадаад суваг байхгүй	Гадаад суваг байхгүй	Гадаад суваг байхгүй
9	Юнивишн ХХК	Шаардлага хангаж байна	33%	шаардлага хангана	Шаардлага хангасан
10	ДДэш ТВ ХХК	Шаардлага хангаж байна	37,5%	шаардлага хангана	Шаардлага хангасан
11	Эн Би Си ХХК	Шаардлага хангаж байна	31.70%	шаардлага хангана	Шаардлага хангасан
12	Скаймедиа корпораци ХХК	Шаардлага хангаж байна	Гадаад суваг байхгүй	Гадаад суваг байхгүй	Гадаад суваг байхгүй
13	Хийморь кабелин телевиз ХХК				




Үндсэн багцын сувгийн дараалал

ОСДҮЭ-н үндсэн багцын сувгийн дараалалд хяналт хийхэд 4 газар нь шаардлага хангаагүй



Гадаад сувгийн эзлэх хувь

Нийт 7 газар гадаад сувгийн эзлэх хувь нь үндсэн багцын нийт сувгийн 30%-нас хэтрэлттэй 3 ОСДҮЭ-нь гадаад суваг ашигладаггүй



Гадаадын аль нэг улсын сувгийн эзлэх хувь

Үндсэн багцад гадаадын аль нэг суваг нийт гадаадын сувгийн 30%-нас хэтрэхгүй байх заалтыг 1 газар зөрчсөн



Гадаадын телевизийн суваг зөвхөн нэг улсынх биш байх

Үндсэн багц дахь гадаадын телевизийн сувгуудын эзэмшил зөвхөн нэг улсынх биш байх гэсэн заалтыг бүх ОСДҮЭ-д хангаж байна

6. Техник стандарт, тасралтгүй ажиллагаанд тавигдах шаардлага хангасан байдал:

Дамжуулж буй радио, телевизийн дохионд хэмжилт хийх зохицуулалтын журмыг баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тогтсон хуваарийн дагуу хэмжилт тохируулгыг хийдэг 8 олон сувгийн үйлчилгээ эрхлэгч байсан ба журам болон хуваарь байхгүй 1, хэмжилт хийх шаардлагагүй 1, журам байхгүй ч тогтсон хуваарийн дагуу тогтмол хэмжилт хийж, тэмдэглэл хөтөлдөг 2 үйлчилгээ эрхлэгч байна.

Дууны түвшинг Европын өргөн нэвтрүүлгийн холбооноос баталсан EBU R128 зөвлөмж болон дүрсийн сигналыг холбогдох стандартын дагуу дамжуулж байгаа үйлчилгээ эрхлэгчид дийлэнх нь хэдий ч техник тоног төхөөрөмжийн боломжгүйгээс ирж байгаа сигналыг боловсруулалт хийлгүй дамжуулж буй үйлчилгээ эрхлэгчид ч мөн байна.

Үзлэг үйлчилгээний хуваарийг батлуулан, батлагдсан хуваарийн дагуу тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж тогтмол үзлэг, үйлчилгээг хийдэг эсэх үзүүлэлтээр: олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн 10 нь журам батлуулж, үзлэг үйлчилгээ хийх хуваарийг жил, сар, 7 хоногоор нь батлуулж, журмын дагуу үзлэг үйлчилгээг хийдэг.

Бүх үйлчилгээ эрхлэгчид нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж нөөц төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгах ба асуудал гарсан үед автоматаар шилжин ажиллах боломжтой. Цахилгаан тэжээлийн нөөцийг бүрдүүлж зарим үйлчилгээ эрхлэгч нь УБЦТС-н цахилгааны 2 талын тэжээлтэйгээс гадна UPS болон генераторын нөөц тэжээлтэй. Зарим нь UPS болон генераторын нөөц тэжээлтэйгээр тоног төхөөрөмжийн байнгын тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Шалгалтын дүнгээр авсан арга хэмжээний талаар:

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/318 тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалтыг хийж үйлчилгээ эрхлэгч тус бүрээр тайланг боловсруулж, аргачлалын дагуу үнэлэлт, дүгнэлтийг хийсэн. Хяналт шалгалтын дэлгэрэнгүй тайлан мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн Даргын зөвлөлийн хурал, 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Хорооны хуралдаанд танилцуулж, нийт 7 үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэх, нийт 2 үйлчилгээ эрхлэгчдэд хугацаатай шаардлага хүргүүлэх, нийт 4 үйлчилгээ эрхлэгчдэд хугацаатай үүрэг даалгавар өгөхөөр ажиллаж байна.